



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/155/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Азбаяр Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/	2021.12.31 ... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/	2021.12.31 ... 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/	2021.12.31... 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/	2021.12.31..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/	2021.12.31 ... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/	2021.12.31 .. 10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт	15
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Төлбөрийн акт	16
4.1 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

Ауд. Д. 25 № *2/42*

БАЯНХОНГОР АЙМГИЙН ТҮҮХ
УГСААТНЫ ЗҮЙН МУЗЕЙН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Р.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

005020300

D:\Alban bichig\A4-toot.docx

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,948,508.01	24,782,486.01
33	АВЛАГА	1,187,781.00	3,860,540.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	82,022.00
335	Бусад авлага	1,187,781.00	3,778,518.00
3351	Байгууллагаас авах авлага	1,187,781.00	3,778,518.00
34	УРЬДЧИЛГАА	200,000.00	00.00
3471	Урьдчилгаа тооцоо	200,000.00	00.00
34713	Цалингийн урьдчилгаа	200,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,560,727.01	20,921,946.01
354	Хангамжийн материал	24,560,727.01	20,921,946.01
35410	Бичиг хэргийн материал	2,426,975.00	522,250.00
35420	Аж ахуйн материал	19,320,776.01	17,021,521.01
35440	Түлш, шатах тослох материал	2,807,476.00	3,378,175.00
35470	Бусад хангамжийн материал	5,500.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,685,888,902.50	1,690,246,082.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,685,888,902.50	1,690,246,082.16
392	Биет хөрөнгө	1,591,888,902.50	1,596,246,082.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	676,119,752.88	682,208,052.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	(18,456,002.46)	(19,915,636.12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	19,000,000.00	19,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,525,000.01)	(19,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	65,547,234.00	65,547,234.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(52,169,457.60)	(55,913,255.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,784,368.58	47,784,368.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,026,426.00)	(36,153,670.31)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	904,458,985.00	908,586,985.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,852,755.00	9,852,755.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,799,310.89)	(9,852,755.00)
39217	Ном	4,102,004.00	4,102,004.00
393	Биет бус хөрөнгө	94,000,000.00	94,000,000.00
39301	Программ хангамж	1,070,000.00	1,070,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,070,000.00)	(1,070,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	94,000,000.00	94,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,711,837,410.51	1,715,028,568.17
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,667,695.59	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,667,695.59	00.00
413	Өглөг	1,667,695.59	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,667,695.59	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,710,169,714.92	1,715,028,568.17
51	Засгийн газрын хувь оролцоо	1,710,169,714.92	1,715,028,568.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	476,396,106.72	476,396,106.72
51101	Өмч: - төрийн	476,396,106.72	476,396,106.72
512	Хуримтлагдсан үр дүн	387,465,716.91	704,187,492.76
51210	Өмнөх үеийн үр дүн	387,465,716.91	699,328,639.51
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	4,858,853.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	846,307,891.29	534,444,968.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,711,837,410.51	1,715,028,568.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	351,019,900.00	330,393,680.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,508,300.00	4,132,980.00
120	Нийтлэг татварын бус орлого	26,508,300.00	4,132,980.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,508,300.00	4,980.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	4,980.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	26,508,300.00	00.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	0.00	4,128,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,734,500.00	326,260,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	319,777,100.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,734,500.00	3,734,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,734,500.00	3,734,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	322,526,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	322,526,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	342,276,050.71	325,534,826.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	342,276,050.71	325,534,826.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	290,284,033.03	278,156,848.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,125,228.00	169,169,296.36
210101	Үндсэн цалин	176,046,090.00	169,169,296.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	79,138.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,611,483.91	21,787,426.88
210201	Тэтгэврийн даатгал	15,363,767.59	14,393,707.61
210202	Тэтгэмжийн даатгал	1,585,900.00	1,389,177.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,268,800.00	917,153.41
210204	Ажилгүйдлийн даатгал	317,200.00	897,907.88
210205	Эрүүл мэндийн даатгал	3,075,816.32	4,189,480.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,087,112.00	61,197,916.00
210301	Гэрэл, цахилгаан	2,008,639.00	2,321,346.00
210302	Түлш, халаалт	58,078,473.00	58,426,570.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	450,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,729,757.00	7,877,294.00
210401	Бичиг хэрэг	524,740.00	2,045,905.00
210402	Тээвэр, шатахуун	765,500.00	960,401.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	769,317.00	1,463,108.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	670,200.00	2,055,000.00
210408	Бараа материал акалсны зардал	00.00	1,352,880.00
2105	Нормативт зардал	00.00	1,232,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	422,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	809,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	5,241,375.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,233,500.00
210602	Тавилга	00.00	1,113,175.00
210604	Урсгал засвар	00.00	2,894,700.00

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	298,000.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	298,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,066,280.00	1,154,920.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	169,300.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	112,900.00	112,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,000.00	44,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	707,080.00	715,520.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,366,172.12	9,996,120.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,270,500.00	4,137,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,095,672.12	5,859,120.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,992,017.68	47,377,978.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	42,531,609.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	42,031,609.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	51,492,017.68	4,846,369.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,492,017.68	4,846,369.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,743,849.29	4,858,853.25
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,743,849.29	4,858,853.25

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	324,511,600.00	326,265,680.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	4,980.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	4,980.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	4,980.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	4,980.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	324,511,600.00	326,260,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	319,777,100.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,734,500.00	3,734,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,734,500.00	3,734,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	322,526,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	322,526,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	322,128,700.00	320,177,380.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	322,128,700.00	320,177,380.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	270,136,682.32	272,509,810.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	173,008,800.00	170,429,422.95
210101	Үндсэн цалин	159,328,800.00	159,504,519.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,680,000.00	10,924,903.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,260,216.32	21,787,426.88

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	16,435,800.00	15,311,422.10
210202	Тэтгэмжийн даатгал	1,730,100.00	1,701,433.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,384,100.00	1,361,146.76
210204	Ажилгүйдлийн даатгал	346,000.00	310,311.41
210205	Эрүүл мэндийн даатгал	3,364,216.32	3,103,113.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,729,169.00	61,197,916.00
210301	Гэрэл, цахилгаан	2,008,639.00	2,321,346.00
210302	Түлш, халаалт	56,720,530.00	58,426,570.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	450,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,694,017.00	4,175,188.00
210401	Бичиг хэрэг	841,100.00	1,010,980.00
210402	Тээвэр, шатахуун	1,531,100.00	1,531,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	854,317.00	1,123,108.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	467,500.00	510,000.00
2105	Нормативт зардал	309,700.00	809,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	309,700.00	809,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	5,485,437.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	500,000.00	00.00
210604	Урсгал засвар	00.00	5,485,437.00
2107	Томилолт, зочны зардал	298,000.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	298,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,066,280.00	1,154,920.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	169,300.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	112,900.00	112,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,000.00	44,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	707,080.00	715,520.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,270,500.00	6,969,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,270,500.00	6,969,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,992,017.68	47,667,569.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	42,821,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	42,321,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	47,757,517.68	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,757,517.68	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,734,500.00	4,846,369.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,734,500.00	4,846,369.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,382,900.00</u>	<u>6,088,300.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,382,900.00	6,088,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,382,900.00	6,088,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,382,900.00	6,088,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,382,900.00	6,088,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-2,382,900.00</u>	<u>-6,088,300.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	382,396,106.72	798,428,267.46	(106,548,012.00)	00.00	1,074,276,362.18
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	382,396,106.72	798,428,267.46	(106,548,012.00)	00.00	1,074,276,362.18
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(9,243,228.05)	00.00	(9,243,228.05)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	476,396,106.72	846,307,891.29	387,465,716.91	00.00	1,710,169,714.92
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	476,396,106.72	846,307,891.29	387,465,716.91	00.00	1,710,169,714.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	311,862,922.60	00.00	311,862,922.60
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	476,396,106.72	846,307,891.29	699,328,639.51	00.00	2,022,032,637.52
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	(311,862,922.60)	00.00	00.00	(311,862,922.60)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,858,853.25	00.00	4,858,853.25
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	476,396,106.72	534,444,968.69	704,187,492.76	00.00	1,715,028,568.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Код	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	322,526,200.00	317,811,530.83	4,714,669.17	98.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	322,526,200.00	317,811,530.83	4,714,669.17	98.5

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	279,705,000.00	274,990,330.83	4,714,669.17	98.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	173,008,800.00	170,429,422.95	2,579,377.05	98.5
210101	Үндсэн цалин	159,328,800.00	159,504,519.05	(175,719.05)	100.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,680,000.00	10,924,903.90	2,755,096.10	79.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,356,200.00	21,787,426.88	1,568,773.12	93.3
210201	Тэтгэврийн даатгал	16,435,800.00	15,311,422.10	1,124,377.90	93.2
210202	Тэтгэмжийн даатгал	1,730,100.00	1,701,433.61	28,666.39	98.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,384,100.00	1,361,146.76	22,953.24	98.3
210204	Ажилгүйдлийн даатгал	346,000.00	310,311.41	35,688.59	89.7
210205	Эрүүл мэндийн даатгал	3,460,200.00	3,103,113.00	357,087.00	89.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,225,400.00	61,197,916.00	27,484.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	2,284,200.00	2,321,346.00	(37,146.00)	101.6
210302	Түлш, халаалт	58,491,200.00	58,426,570.00	64,630.00	99.9
210303	Цэвэр, бохир ус	450,000.00	450,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4,680,500.00	4,170,208.00	510,292.00	89.1
210401	Бичиг хэрэг	1,101,000.00	1,006,000.00	95,000.00	91.4
210402	Тээвэр, шатахуун	1,531,100.00	1,531,100.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,538,400.00	1,123,108.00	415,292.00	73.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	510,000.00	510,000.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	809,700.00	809,700.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	809,700.00	809,700.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,968,800.00	10,968,737.00	63.00	100.0
210604	Урсгал засвар	10,968,800.00	10,968,737.00	63.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	500,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	500,000.00	500,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,155,600.00	1,154,920.00	680.00	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	112,900.00	112,400.00	500.00	99.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,000.00	44,000.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	715,700.00	715,520.00	180.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	3,972,000.00	28,000.00	99.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	3,972,000.00	28,000.00	99.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,821,200.00	42,821,200.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,821,200.00	42,821,200.00	0.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,321,200.00	42,321,200.00	0.00	100.0

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	322,526,200.00	317,811,530.83	4,714,669.17	98.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	322,526,200.00	317,811,530.83	4,714,669.17	98.5
132001	Орон нутгийн төсвөөс	322,526,200.00	317,811,530.83	4,714,669.17	98.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	15.00	15.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	07.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,734,500.00	3,602,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,734,500.00	3,602,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,734,500.00	3,602,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,734,500.00	3,602,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,734,500.00	3,602,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,734,500.00	3,602,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,734,500.00	3,602,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,734,500.00	3,602,800.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Түүх угсаатны музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт төсвийн гүйцэтгэлийн аудит хийлгэх хүсэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны музейн 2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг 2021.01.01-2021.02.28 хүртэл А.Мандах, 2021.03.01-2021.12.31-ний өдөр хүртэл Р.Пүрэвсүрэн, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Намсрай нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Түүх угсаатны музейн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Чиг үүрэг. Музей, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах үйл ажиллагаа.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүү, хяналт аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Түүх угсаатны музейн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 342,276.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,422.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,395.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцож 2395.9 мянган төгрөгөөр тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцож 2,278.7 мянган төгрөг болгон шинэчлэн тогтоов.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Түүх угсаатны музейн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,191.2 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,948.5	24,782.5	(1,166.0)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,187.8	3,860.5	2,672.8
Урьдчилгаа	200.0	-	(200.0)
Бараа материал	24,560.7	20,921.9	(3,638.8)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,685,888.9	1,690,246.1	4,357.2
Үндсэн хөрөнгө	1,821,935.1	1,832,151.4	10,216.3
Хуримтлагдсан элэгдэл	(136,046.2)	(141,905.3)	(5,859.1)
Нийт хөрөнгө	1,711,837.4	1,715,028.6	3,191.2
Өр төлбөр	1,667.7	-	(1,667.7)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,710,169.7	1,715,028.6	4,858.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,711,837.4	1,715,028.6	3,191.2

Өмнөх онд авлагын данс 1,187.8 мянган төгрөг байсан бол тайлант онд 3,860.5 мянган төгрөг болж 2,672.8 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд авлага өссөн шалтгаан нь байгууллагын цахилгааны монтажид гэмтэл гарч “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-д засвар хийлгэхээр төлбөр хийсэнтэй холбоотой байна. Харин оны эхний 1,187.8 мянган төгрөгийн авлага нь 2005 оноос үүссэн насжилт ихтэй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 20,921.9 мянган төгрөг болж 3,638.8 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал 2,299.3 мянга, бичиг хэргийн материал 1,904.7 мянга, төгрөгөөр буурсан бол түлш шатах тослох материал 570.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,832,151.4 мянган төгрөг болж 10,216.3 мянган төгрөгөөр өссөн нь 4,128.0 мянган төгрөгийн түүх дурсгалын зүйлийг үнэ төлбөргүй авсан бол 6,088.3 мянган төгрөгийн төсвийн хөрөнгөөр дотор гадна хаалга, гражийн хаалга зэргийг бэлтгэсэн байна. Тайлант онд хөрөнгө актлаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,715,028.6 мянган төгрөг болж 4,858.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тайлант онд дахин үнэлгээний дансыг 311,862.9 мянган төгрөгөөр бууруулах бичилт хийж өмнөх үеийн үр дүнг бууруулсан нь өмнөх оны хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг 301,843.1 мянган төгрөгөөр тооцож санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвөөс санхүүжихээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,788.5 мянган төгрөгөөр нэмж 304,631.6 мянган төгрөгөөр анх батлагдсан байна. Төсөвлөсөн зардлаас цалингийн зардлыг 25,756.6 мянга, хангамж материалын зардлыг 507.5 мянган төгрөгөөр нэмсэн бол татаас шилжүүлгийн зардлыг 18,981.7 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 322,526.2 мянган төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр төсвөөс 322,526.2 мянган төгрөгийн санхүүжилт авч 317,811.5 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 4,714.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 317,811.5 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байгаа бөгөөд тайлант онд цалингийн зардлыг 2,579.4 мянга, ЭМНДШ-ийн зардлыг 1,568.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 27.5 мянга, хангамж материалын зардлыг 510.3 мянган төгрөгөөр хэмнэсэн нь нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллага нь 2021 онд нэмэлт санхүүжилтийн дансаар 3,734.5 мянган төгрөгийн өмнөх оны үлдэгдэл хуваарилагдсаны 3,180.0 мянган төгрөгөөр мал худалдан авч, 422.8 мянган төгрөгийн малын эм тарианд зарцуулан оны эцэст 131.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Орон нутгийн өмчийн газар нь 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг 98.9%-тай дүгнүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 325,534.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 16,741.2 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа үйлчилгээний бусад зардал буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 426,197.4 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллийг байршуулахаас 394,464.2 мянган төгрөгийн 127 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 31,733.2 мянган төгрөгийн 22 мэдээг хугацаа хоцроож байршуулсан тул Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх зөвлөмжийг төсөв захирагчид өгөв. Харин 2 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	7	2	2
2	Хагас жил	4	4	3	1	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	30	6	0
5	Тухай бүр	8	96	83	13	0
6	Нийт	27	151	127	22	2

3.9.2 ЗАСГИЙН "ТӨСВИЙН ХЭМНЭЛТИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ" 43 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Тайлант онд 326,134.0 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж гүйцэтгэлээр 317,816.5 мянган төгрөгийг зарцуулж, 8,317.5 мянган төгрөг буюу 2.6 хувийг хэмнэсэн байна.

- Албан томилолтын зардлыг 527.9 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 500.0 мянган төгрөг зарцуулж 27.9 мянган төгрөг хэмнэжээ.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 71,138.7 мянган төгрөгөөр төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 61,197.9 мянган төгрөг зарцуулж, анх баталсан дүнгээс 9,940.8 мянган төгрөг буюу 14.0 хувь хэмнэсэн нь ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20 хувь бууруулж хэмнэх дээрх тогтоолын 1.8 дах заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.9.3 БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд аймгийн хэмжээнд улс, орон нутгийн төсөвтэй холбоотой 116 худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 355.8 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосныг 2021 оны 06 дугаар сарын 21-нд орон нутгийн орлогын дансанд, хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой 1 зөвлөмж өгснийг газрын даргын 2021 оны 46 тоот албан бичгээр биелэлтийг ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 38,148.2 мянган төгрөгийн 4 зөрчил илэрч, 1,844.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 36,303.7 мянган төгрөгийн 3 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

4.1 Төлбөрийн акт

1.1. Цалингийн зардлыг давтан тооцоолж, ЭМНДШ-ийн ногдуулалтыг 2021 оны 1-р сард гарт олгох дүнгээр НДШ-ийн цалин түүнтэй адилтгах орлогыг мэдээлсэн, 2021 оны 9-р сард 677.8 мянган төгрөгийг 5,677.8 мянган төгрөг гэж орон алдаж мэдээлсэн, 2021 оны 10 дугаар сард 1 хүний 605.3 мянган төгрөгийн цалинг мэдээлээгүй орхигдуулсан нь Нийгмийн даатгалыг тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1¹ дэх хэсэгт заасан заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаатай мэдээ гаргаснаас 2021 оны 9 дүгээр сард илүү мэдээлсэн 5,000.0 мянган төгрөгт ногдох 1,030.1 мянган төгрөгийн шимтгэлийг Нийгмийн даатгалын байгууллагатай хийх тооцооноос суутган тооцож, 1,10 дугаар сард дутуу мэдээлсэн 814.4 мянган төгрөгийн ногдуулалтыг дээрх төлбөрөөс суутган тооцохоор, зөрүү 216.7 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх нийт 1,844.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд тулгалт хийхэд аж ахуйн материалын орлого 71.9 мянга, шатахуун 12.1 мянга, зарлага аж ахуйн материал 72.0 мянга, шатахуун 127.6 мянга, бусад хангамж 5.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4² дэх заалтыг зөрчжээ.

1.2. Өгсөн зөвлөмж:

Эд хариуцагчийн тайланг хүлээн авч нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө анхан шатны баримтын дагуу тайланг бүрэн, үнэн зөв гаргаж буйд хяналт тавьж ажиллах. Мөн аудитаар зөрүүтэй гарсан тайланг үнэн зөв гаргаж зөрчлийг арилгасан талаар хэрэгжилтийн тайланг ирүүлэх.

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 71,138.7 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 61,197.9 мянган төгрөг зарцуулж Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8³ дахь заалтаар 20 хувь буюу 14,227.7 мянган төгрөг хэмнэхээс 9,940.8 мянган төгрөг буюу 14.0 хувь хэмнэсэн нь тогтоолыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

¹ Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ.

² Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.

³ Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах

Цаашид байгууллагын удирдлага Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол, журмыг хэрэгжүүлэн ажиллах.

3.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд оруулбал зохих 426,197.4 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллийг байршуулахаас 394,464.2 мянган төгрөгийн 127 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 31,733.2 мянган төгрөгийн 22 мэдээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээг цаг хугацаанд нь байршуулж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	Санхүүгийн аудит										
1	ТШЗ	1	2,128.1	0	0	1	1,844.5	0	0	1	283.6
	Дүн	1	2,128.1	0	0	1	1,844.5	0	0	1	283.6
	Нийцлийн аудит										
1	ТШЗ	1	36,020.1	0	0	0	0	0	0	1	36,020.1
	Дүн	1	36,020.1	0	0	0	0	0	0	1	36,020.1
	НИЙТ	2	38,148.2	0	0	1	1,844.5	0	0	2	36,303.7

_____оОо_____



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 49

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлыг давтан тооцоход ЭМНДШ-ийн ногдуулалтыг 2021 оны 1-р сард 14,394.9 мянган бодогдсон цалинг гарт олгох дүн 11,746.2 мянган төгрөгөөр мэдээлсэн, 2021 оны 9-р сард 677.8 мянган төгрөгийн 1 хүний цалинг 5,677.8 мянган төгрөгөөр мэдээлсэн, 2021 оны 10 дугаар сард 1 хүний 605.3 мянган төгрөгийн цалинг мэдээлээгүй орхигдуулсан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ” гэсэн зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5 дахь “бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Алдаатай мэдээ гаргаснаас 2021 оны 9 дүгээр сард илүү мэдээлсэн 5,000.0 мянган төгрөгт ногдох 1,030.1 мянган төгрөгийн шимтгэл, 2021 оны 1,10 дугаар сард

005050114

дутуу мэдээлсэн 814.4 мянган төгрөгийн шимтгэлийн ногдуулалтыг суутган тооцон нийт 1844.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосны 216.7 мянган төгрөгийн зөрүү төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн захирал Р.Пүрэвсүрэн, нягтлан бодогч Б.Намсрай нарт хариуцуулав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЭНЯМ

АУДИТОР:

Б.АЗБАЯР



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**АЛБАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХУУДАС**

А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1. Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музей		1.2 Аудитын код	БНА-2022/155/НА-СТА-ТШЗ	
1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл		1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит	
1.5 Төлбөрийн актын дугаар	49/А0560236/ БНА- 2022/155/НА- СТА-ТШЗ	1.6 Огноо	2022.02.25	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	1,844,450
1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Алдаа, зөрчлийн товч утга	Цалингийн зардлыг давтан тооцоолж, ЭМНДШ-ийн ногдуулалтыг 2021 оны 1-р сард гарт олгох дүнгээр НДШ-ийн цалин түүнтэй адилтгах орлогыг мэдээлсэн, 2021 оны 9-р сард 677.8 мянган төгрөгийг 5,677.8 мянган төгрөг гэж орон алдаж мэдээлсэн, 2021 оны 10 дугаар сард 1 хүний 605.3 мянган төгрөгийн цалинг мэдээлээгүй орхигдуулсан байна.			
	Алдаа, зөрчлийн ангилал	Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой.			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	4.2.3.5 дахь "бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн"			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Нийгмийн даатгалын тухай хууль		
		Заалт	"Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ"		
Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Төрийн аудитын тухай хууль			
	Заалт	21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно"			
1.9 Төлбөр барагдуулах хэлбэр /Төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд			1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо	
	Орон нутгийн төсвийн дансанд		1,844,450		
	Тухайн байгууллагын дансанд				
2022.05.30					

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Төлбөрийн хүсэлт			
2	Цалингийн цэст	01,09,10-р сар		Нийгмийн даатгалын мэдээ, цалингийн цэст

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			Холбоо барих хаяг, утас
	Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	
1	Б.АЗБАЯР	Аудитор	Баянхонгор аймгийн Түүх	Дарга	Р.Пүрэвсүрэн	8889663
2				Нягтлан бодогч	Б.Намсрай	99445696

	Дүн									

1.3 Албан шаардлага, төлбөрийн актыг хэрэгжүүлээд гарсан үр дүн

№	Албан шаардлага, төлбөрийн актыг заалтын дугаар	Албан шаардлага, төлбөрийн актыг хэрэгжүүлээд гарсан үр дүнгийн талаарх товч мэдээлэл		Биелэлт хувиар	
		Шалгагдагч этгээд ирүүлсэн баримт, мэдээллээр	Хариуцсан аудиторын шалгаснаар	Шалгагдагч этгээдийн гаргасан	Аудитын багийн санал

1.4 Албан шаардлага, төлбөрийн актыг биелэлт хугацааны хувьд

Үзүүлэлт	Дүн (төгрөг)							
 Он			 Он			
	I улирал	II улирал	III улирал	IV улирал	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Тайлант хугацааны эхний үлдэгдэл								
Аудитын явцад								
Хугацаандаа								
Хугацаа хоцорсон	30 хүртэл хоног							
	30-90 хоног							
	90-ээс дээш хоног							
Тайлант хугацааны эцсийн үлдэгдэл								
Дүн								

1.5 Хүлээн зөвшөөрүүлсэн үр өгөөж

№	Санхүүгийн			Санхүүгийн бус		Тайлбар
	Товч утга	Тоо	Дүн	Тоо	Товч утга	

2. Бүртгэлээс хасагдсан албан шаардлага, төлбөрийн акт

№	Бүртгэлээс хасагдсан							Шалтгаан
	Хуулийн байгууллагад шилжүүлсэн			Тушаалаар хүчингүй болгосон				
	Шилжүүлсэн шийдвэрийн			Мөнгөн дүн (Төгрөгөөр)	Хүчингүй болгосон тушаалын		Мөнгөн дүн (Төгрөгөөр)	
	Нэр	Огноо	Дугаар		Огноо	Дугаар		

3. Албан шаардлага, төлбөрийн актыг биелэлт тооцох үеийн чанарын хяналт

№	Хяналт хийсэн албан тушаалтан	Хянасан огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Биелэлтийг хянаж статистик мэдээнд тусгахыг зөвшөөрсөн ажилтны гарын үсэг

БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН ХУУДАС ХӨТӨЛСӨН:

Албан тушаал:

Овог нэр: Огноо: